20	2024.				
21	2024.				
22	2024.				
23	2024.				
24	2024.				
25	2024.				
26	2024.				
27	2024.				
28	2024.				

"Бодит-Орд" ХХК-ийн Тасуурын нэрвэл:

О.Эрдэнбэт.

“Цэвэр-Хот” орон нутгийн өмчит ААТҮГ-т хоёрдогч тушаах гэрээ

БАТЛАВ
ЦЭВЭР ХОТ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ-с О.А. Ц.БАЯСГАЛАН
2024. оны 4 сарын 30

БАЯЛАГ ОРД
ХХК-ЫН
ӨСӨӨ ЧУЛУУТЫН
УУГ БАТЛАВ
“БАЯЛАГ ОРД ХХК” ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.ГАНБААТАР
2024. оны 4 сарын 30

ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

№ 225

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэрээний зорилго: Ахуйн болон үйлдвэрлэлийн ангилсан хог хаягдлыг цуглуулж ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэж ажиллах талаар иргэн, байгууллага, аж ахуйн нэгжтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажил гүйцэтгэх гэрээг байгуулах, хэрэгжүүлэх, дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү гэрээний эрх зүйн үндэслэл нь Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйл, Зөрчлийн тухай хуулийн 6.16 дугаар зүйл, Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг шинэчлэн тогтоох тухай Баянхонгор сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны 12/73 тогтоолыг тус тус үндэслэнэ.

1.3. Энэхүү гэрээний хэрэгжилтэд тухайн байгууллагын удирдах ажилтнууд болон сумын Засаг дарга, ажлын алба, хөндлөнгийн хяналтын байгууллага, хууль журам гэрээгээр тохирсон хэм хэмжээнд хяналт тавина.

1.4. Хог хаягдлыг ангилан ялгах байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах.

Хоёр. Гэрээ байгуулагч талууд

2.1. Гэрээг нэг талаас “Цэвэр хот ОНӨААТҮГ”-ыг төлөөлж цаашид “тээвэрлэгч гэх” орлогын байцаагч ажилтай М.Алимаа нөгөө талаас “Тээвэрлүүлэгч гэх” “БАЯЛАГ ОРД ХХК” ийг төлөөлж Т. ДАВСРАЛ нар харилцан тохиролцон энэхүү гэрээг байгуулав.

Гурав. Тээвэрлэгчийн эрх үүрэг

3.1. Хог хаягдлын хэмжээг Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 07 сарын 19-ний өдрийн 191, А/243 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлалын дагуу тооцож, төлбөр хураамжийн үнийн тарифыг тогтоож Баянхонгор сумын ИТХ-аар батлуулсан байна.

3.2. Хог хаягдал тээвэрлэх чиглэл, хуваарийг тогтоож Баянхонгор Сумын Засаг даргаар батлуулан мөрдөж ажиллана.

3.3. Баянхонгор сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшил, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг тогтоосон хуваарийн дагуу зориулалтын тээврийн хэрэгслээр ачиж тээвэрлэн нэгдсэн хогийн цэгт хүргэн дарж булшлах, хог хаягдлын түрэлтийн үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

3.4. Барилгын болон хортой, тусгай хог хаягдлыг холбогдох журмын дагуу тээвэрлэнэ.

3.5. Уул уурхай, аж ахуй нэгж, хувийн хэвшилүүдийн ахуйн хог хаягдлыг ачиж тээвэрлэнэ.

3.6. Гүйцэтгэгч нь ажил үйлчилгээ үзүүлсэн төлбөрийг нэхэмжлэх, заасан хугацаанд төлөхийг шаардах эрхтэй (Зөрчлийн тухай хуулийн 6.16 дугаар зүйл заалт)

3.7. Тухайн байгууллага, аж ахуй нэгж, хувийн хэвшил, иргэн хог хаягдлын төлбөр тооцоо хийгдээгүй тохиолдолд хог хаягдлыг тээвэрлэхгүй ба түүнээс гарсан асуудлыг Цэвэр хот ОНӨААТҮГ-аар хариуцахгүй болно.

3.8. Хог хаягдлыг тээвэрлэх тээврийн хэрэгсэл буюу авто машинууд нь зориулалтын битүүмжлэлтэй аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

3.9. Нэгдсэн хогийн цэгт иргэн аж ахуй нэгж байгууллага нь ахуйн хог, барилгын хог, болон мал амьтны гаралтай хог хаягдлыг асгасан тохиолдол тус байгууллагад түрэлтийн төлбөрийг Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг шинэчлэн тогтоох тухай Баянхонгор сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны 12/73 тогтоолыг дагуу төлнө.

Дөрөв. Тээвэрлүүлэгчийн эрх, үүрэг

4.1. Хог тээврийн гэрээний төсөлтэй танилцаж, хог хаягдлын тухай хуулийн 10.2.3-т заасны дагуу гэрээ байгуулах

4.2. Гэрээний дагуу хог хаягдлаа сардаа тогтмолоор хуваарийн дагуу ачуулах

4.3. ХХТХ-ийн 10.2.2-т заасны дагуу хог хаягдлыг түр хадгалах савны стандартыг хангасан хогийн савтай байх /галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар

тархах, хур тундасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн/, ХХТХ-ийн 10.2.1-т заасны дагуу ангилан ялгах

4.4 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг ХХТХ-ийн 10.2.7-т заасны дагуу тогтоосон хугацаанд төлөх

4.5 Тухайн аж ахуйн нэгж, байгууллага, орчин тойрныхоо 50-100 метр хүртэлх зайг цэвэрлэж тээвэрлүүлэх.

4.6 Нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох, хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх

4.7 Хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаяхыг хориглоно

4.8 Нийтийн эдэлбэр газар, ногоон бүсэд хог хаяхыг хориглоно

4.9 Хог хаягдлыг ил задгай шатаахыг хориглоно

4.10 Дээрх зүйл заалтуудыг зөрчсөн тохиолдолд зөрчлийн тухай хуулийн 6.16 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээнэ.

4.11 Хог хаягдлын үйлчилгээтэй холбоотой санал гомдлыг 7044-4200, 90104200 утсаар мэдээллэнэ.

Тав.Төлбөрийн нөхцөл

5.1 Хог хаягдлын тухай хуулийн 41.1 дүгээр зүйл заалтыг үндэслэн хог хаягдал тээвэрлүүлэлтийн хураамжийг /Баянхонгор сумын иргэдийн хурлын 2023.12.18 12\73 тогтоолоор батлагдсан төлбөрийн хэмжээгээр ахуйн хог болон аюултай хог **225000** төгрөгийг Төрийн сангийн данс болох 100032000947 тоот дансанд сар бүрийн 28-ны дотор тогтмол тушаана.

Зургаа. Гэрээний хугацаа

6.1 Гэрээ нь 2024 оны 01 сарын -ны өдрөөс 2024 оны 12 сарын 31-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

6.2 Гэрээний хугацаа дуусгавар болохоос ажлын 10 хоногийн өмнө тээвэрлүүлэгч талаас гэрээг сунгах хүсэлт ирүүлээгүй тохиолдолд гэрээг хүчингүйд тооцож хог тээвэрлэлтийг бүрэн зогсооно.

6.3 Холбогдох байгууллагууд үйл ажиллагаагаа бүр мөсөн зогсоосон нь нотлогдсон тохиолдолд уг гэрээг дуусгавар болсонд тооцно.

Долоо. Талуудын хариуцлага, маргаан шийдвэрлэх журам

7.1 Талууд хагас бүтэн жилээр гэрээний биелэлтийг дүгнэж, цаашид илүү үр дүнтэй хамтран ажиллах боломжийг тодорхойлж тооцоо нийлнэ.

7.2 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хог хаягдлын тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан зүйл заалтын дагуу хариуцлага хүлээнэ.


7.3 Энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэх боломжгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

Найм. Бусад

8.1 Гэрээ нь талууд батлаж, гарын үсэг зурж тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.


8.2 Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Гэрээний нэмэлт өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

8.3 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд нэг хувийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нөгөө хувийг нь тус байгууллага хадгална.

ТЭЭВЭРЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
ЦЭВЭР ХОТ ОНӨААТҮГ-Г
ТӨЛӨӨЛЖ ОРЛОГЫН БАЙЦААГЧ:
 М.АЛИМАА

Хаяг: Номгон 1 дүгээр баг
Дөвөнтийн заалны 2 дугаар давхарт
Утас : 70444200, 90104200

ТЭЭВЭРЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
"БАЯЛАГ ОРД ХХК" ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д. ГАНБААТАР-Г


Хаяг: ГАЛУУТ СУМ СУМБЭР 2 -Р БАГ
Утас: 99819988

Цэвэр-Хот” орон нутгийн өмчит ААТҮГ-т хоёрдогч түүхий эд тушаасан баримтын хавсралт



БАЯНХОНГОР АЙМАГ
“ЦЭВЭР ХОТ” ОРОН НУТГИЙН
ӨМЧИТ ААТҮГ

127 дугаар байр, Чандмань гудамж 1,
Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70444200

Цахим шуудан: bayankhongortseverhot@gmail.com

2024. 10. 28 № 157

танай _____-ны № _____-т

Хоёрдогч түүхий эд хүлээн
авсан тухай

Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.4-д зааснаар хог хаягдлаа ангилан ялгаж 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр тус байгууллагад 8 шуудай хуванцар, ажилласан масло 200 литр, агаар шүүгч 8 ширхэг, маслын сав 6 ширхэгийг танай байгууллагын ажилтан инженер Д.Нямсүрэн нь хүлээлгэн өгсөнд талархаж байна.

Цаашид хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.1, 10.2.4-т заасны дагуу хог хаягдлаа ангилан ялгаж, тус байгууллагатай хамтран ажиллана уу.

ЗАХИРАЛ



БАЯСГАЛАН

642403021

ЦЭВЭР ХОТ ОНӨ ААТУГАЗАР ХОЁРДОГЧ ТҮҮХИЙ ЭД
ХҮЛЭЭН АВСАН АЖЛЫН ФОТО ЗУРАГ





УС,ЦАГ УУР,ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

АГААРЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Дугаар
Захиалагч
Сорьц авсан газар
Дээжийн тодорхойлолт
Сорьц авсан огноо
Сорьц авсан хүний нэр, албан тушаал
Шинжилгээний аргын стандарт

2024/07
Баялаг орд—ХХК
Баяновоо сум
Ашиглалтын талбайгаас
2024.09.12
Д.Дэжидмаа /БОШЛ-ийн инженер/
MNS: MNS17.2.5.12:88
MNS17.2.5.11:88
DUSTRAK8530


Шинжээчийн код
Шинжилсэн огноо

02
2024.09.13

ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ҮЗҮҮЛЭЛТ:

№	Сорьц авсан цэг	Хэмжих нэгж	PM-2,5	PM-10	Хүхэрлэг хий (SO ₂)	Азотын исэл (NO ₂)
01	Оффис	мкг/м ³	0.033	0.074	0.008	0.033
02	Ашиглалтын талбай	мкг/м ³	0.045	0.087	0.012	0.047
ЗДХ	MNS4585:2016		50	100	0.450	0.200


Тайлбар: Агаарын чанарын хяналт шинжилгээний түгээмэл тархалттай бохирдуулагч бодис болох, Хүхэрлэг хий/SO₂/, Азотын давхар исэл/NO₂/-ийн явцыг MNS4585:2016 стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас давсан тохиолдол ажиглагдаагүй болно.

УЦУОШТӨВИЙН ДАРГА  Ч.ОЮУНЧИМЭГ
ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН: Д.ДЭЖИДМАА
ЛАБОРАТОРИЙН ИНЖЕНЕР
ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН: А.ЖАВЗАННАМЖИЛ
ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Шинжилгээний дүн нь тухайн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

6/24/24, 1:48 PM

GASI-LIMS



Хүнсний Аюулгүй Байлын
Үндэсний Лавлага Лабораторийн
өрөнхий захирлын 2023 оны 01 сарын
02-ны өдрийн А/02 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт Маягт 00-59

БАЯНХОНГОР АЙМГИЙН СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН СОРИЛТЫН
ЛАБОРАТОРИ

Баянхонгор аймаг, Баянхонгор сум, 1-р баг
Утас: 70442442

ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
CERTIFICATE OF ANALYSIS

Бүртгэлийн дугаар /Registration number/: 24-316

Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан газрын нэр : "Баялаг орд" ХХК. Баянхонгор сум.

/The name of customer's request for analysis/

Дэд лабораторийн нэр /Name of the sub laboratory/: Эрүүл ахуйн нян судлалын хяналтын лаборатори

Дээжийн тодорхойлолт /Sample description/					
Дээжийн дугаар Sample number	Дээжийн нэр Name of sample	Цувралын дугаар Batch number	Үйлдвэрлэсэн улс The country of original manufacturer	Бүтээгдэхүүний хүчинтэй хугацаа Date of expiry	Дээжийн тоо хэмжээ Quantity of the sample
960	Унд ахуйн ус		Монгол Улс	Тодорхойгүй	750.0 мл
961	Тогтоол ус		Монгол Улс	Тодорхойгүй	750.0 мл
962	Гадаа овоолгоны хөрс		Монгол Улс	Тодорхойгүй	500.0 г
963	Шатахуун түгээгүүрийн хөрс		Монгол Улс	Тодорхойгүй	500.0 г

Хүлээн авсан огноо Date of receipt	Шинжилгээ дууссан огноо Date of test completion	Хэвлэсэн огноо Date of issue of the report
2024 он 06 сар 17 өдөр	2024 он 06 сар 24 өдөр	2024 он 06 сар 24 өдөр

Дээжийн дугаар Sample number	Шинжилгээний аргын стандарт Method of analysis	Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж Test parameter, unit	Шаардлага Test specification, unit	Шинжилгээний дүн Test results
960	MNS 6546:2015	<i>Pseudomonas aeruginosa</i>	100мл-д Илрэхгүй	Илрээгүй
	MNS ISO 6222:1998	ББЕТ	1мл-д 100ш ихгүй	22ш
	MNS ISO 19250:2017	<i>Salmonella spp</i>	25мл-д Илрэхгүй	Илрээгүй
	MNS ISO 9308-1:1998	Халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян /ялтас шүүлтүүр/	100мл-д Илрэхгүй	Илрээгүй
961	MNS 6546:2015	<i>Pseudomonas aeruginosa</i>	100мл-д Илрэхгүй	Илрээгүй
	MNS ISO 6222:1998	ББЕТ	1мл-д 100ш ихгүй	97ш
	MNS ISO 19250:2017	<i>Salmonella spp</i>	25мл-д Илрэхгүй	Илрээгүй
	MNS ISO 9308-1:1998	Халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян /ялтас шүүлтүүр/	100мл-д Илрэхгүй	Илрээгүй
962	MNS 6341:2012	Эмгэгтөрөгч нян	1гр-д Илрэхгүй	Илрээгүй
963	MNS 6341:2012	Эмгэгтөрөгч нян	1гр-д Илрэхгүй	Илрээгүй

Санал тайлбар:
Opinions and interpretation

БАТАЛСАН: ЛАБОРАТОРИЙН
Approved by ЭРХЛЭГЧ:



/Ц.МАНБАТ/

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн дээжинд хөмөрнө. Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно.

10/22/24, 10:05 AM

GASI-LIMS



Хүнсний Аюулгүй Байдлын
Үндэсний Лавлагаа Лабораторийн
ерөнхий захирлын 2023 оны 01 сарын
02-ны өдрийн А/02 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт Маягт 00-59

БАЯНХОНГОР АЙМГИЙН СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН СОРИЛТЫН
ЛАБОРАТОРИ

Баянхонгор аймаг, Баянхонгор сум, 1-р баг
Утас: 70442442

ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
CERTIFICATE OF ANALYSIS

Бүртгэлийн дугаар /Registration number/ : 24-501

Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан газрын нэр : "Баялаг орд" ХХК. Баянхонгор сум.
/The name of customer's request for analysis/

Дэд лабораторийн нэр /Name of the sub laboratory/ : Эрүүл ахуйн нян судлалын хяналтын
лаборатори

Дээжийн тодорхойлолт /Sample description/					
Дээжийн дугаар Sample number	Дээжийн нэр Name of sample	Цувралын дугаар Batch number	Үйлдвэрлэсэн улс The country of original manufacturer	Бүтээгдэхүүний хүчинтэй хугацаа Date of expiry	Дээжийн тоо хэмжээ Quantity of the sample
1475	Ундны ус		Монгол Улс	Тодорхойгүй	500.0 мл
1476	Тогтоол ус		Монгол Улс	Тодорхойгүй	250.0 мл
1477	Гадаад овоолгын хөрс		Монгол Улс	Тодорхойгүй	500.0 г
1478	Шатахуун түгээгүүрийн хөрс		Монгол Улс	Тодорхойгүй	500.0 г
Хүлээн авсан огноо Date of receipt		Шинжилгээ дууссан огноо Date of test completion		Хэвлэсэн огноо Date of issue of the report	
2024 он 10 сар 15 өдөр		2024 он 10 сар 18 өдөр		2024 он 10 сар 22 өдөр	


Дээжийн дугаар Sample number	Шинжилгээний аргын стандарт Method of analysis	Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж Test parameter, unit	Шаардлага Test specification, unit	Шинжилгээний дүн Test results
1475	MNS 6546:2015	<i>Pseudomonas aeruginosa</i>	100мл-д Илрэхгүй	Илрээгүй
	MNS ISO 6222:1998	ББЕТ	1мл-д 100ш ихгүй	10ш
	MNS ISO 19250:2017	<i>Salmonella spp</i>	25мл-д Илрэхгүй	Илрээгүй
	CAЗ:1.1.5	Халуунд тэсвэртэй гэдэсний бактерийг илрүүлэх(исгэлтийн арга)	100мл-д Илрэхгүй	Илрээгүй
1476	MNS 6546:2015	<i>Pseudomonas aeruginosa</i>	100мл-д Илрэхгүй	Илрээгүй
	MNS ISO 6222:1998	ББЕТ	1мл-д 100ш ихгүй	70ш
	MNS ISO 19250:2017	<i>Salmonella spp</i>	25мл-д Илрэхгүй	Илрээгүй
	CAЗ:1.1.5	Халуунд тэсвэртэй гэдэсний бактерийг илрүүлэх(исгэлтийн арга)	100мл-д Илрэхгүй	Илрэв
1477	MNS 6341:2012	Эмгэгтөрөгч нян	1гр-д Илрэхгүй	Илрээгүй
1478	MNS 6341:2012	Эмгэгтөрөгч нян	1гр-д Илрэхгүй	Илрээгүй

Санал тайлбар:
Opinions and interpretation

БАТАЛСАН: ЛАБОРАТОРИЙН
Approved by ЭРХЛЭГЧ:

Ц.Маабат
/Ц.МААБАТ/
гарын үсэг/signature/

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн бээжинд хамаарна.
Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно.



ШИНЖЛЭГЭЭНИЙ ДҮН
CERTIFICATE OF ANALYSIS

Дээдний дүгээр	Дээдний нэр	Хүлээх дүнг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг
1478	Шинжлэг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг
1479	Шинжлэг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг
1480	Шинжлэг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг
1481	Шинжлэг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг
1482	Шинжлэг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг
1483	Шинжлэг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг
1484	Шинжлэг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг
1485	Шинжлэг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг
1486	Шинжлэг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг
1487	Шинжлэг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг
1488	Шинжлэг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг
1489	Шинжлэг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг
1490	Шинжлэг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг	Хүлээх дүнг



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН
НУТАГТ ОРШИХ “БАЯЛАГ ОРД” ХХК-ИЙН
МУ-000222 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ӨВӨРЧУЛУУТЫН ХҮРЭН
НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ
ТӨСӨЛ**

**БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ
АУДИТЫН ТАЙЛАН - 2024 ОН**

**Улаанбаатар хот
2024 он**



“НОГООН ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ” ХХК

**Байгаль орчны аудит, байгаль
орчны менежментийн зөвлөх
үйлчилгээ**

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ
“БАЯЛАГ ОРД” ХХК-ИЙН MV-000222 ТООТ АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ “ӨВӨРЧУЛУУТЫН ХҮРЭН
НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСӨЛ”-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТЫН ТАЙЛАН – 2024
ОН**

ГҮЙЦЭТГЭСЭН:

“НОГООН ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ АХЛАХ АУДИТОР

Д.БАТБОЛД

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Хянан баталгааны төрөл: Захиалгат

Огноо: 2020.10.18

1. Газар ашиглагч: “Баялаг-Орд”ХХК

2. Аймаг (нийслэл): Баянхонгор

Сум (дүүрэг): Галуут

3. Байршил, хаяг: Өвөрчулуут

4. Нэгж талбарын дугаар: 6434-Баялаг-Орд-01

5. Хөрсний нэр: 1502- Уулын хүрэн хөрс

6. Ургамалжилт: Н-III-3-5, Дэрс- улалжит

7. Нийт талбайн хэмжээ: 720000м²

8. Газар эзэмших зориулалт: Ашигт малтмал ашиглах

9. Одоогийн газар ашиглалтын хэлбэр: Нүүрсний уурхайн олборлолт

10. Газар ашиглах, эзэмших шийдвэр: АМГТХЭГ-ын 2007 оны 03 дугаар сарын 09 өдрийн MV-000222A тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл

11. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаа: MV-000222

12. Эзэмшил газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт:

Газар ашиглалтын төрөл		Талбай, м ²	Бохирдлын төрөл		
			Физикийн	Химийн	Биологийн
Нийт эзэмшил газар		720000	+	-	-
Нэгж талбарын талбай		720000	+	-	-
А.Зөвшөөрөлтэй ашиглаж байгаа талбай		720000	+	-	-
1.Үйл ажиллагаанд өртөөгүй талбай		613561.8	+	-	-
үүнээс	Ашиглалт явагдаагүй газар	613561.8	+	-	-
2.Үйл ажиллагаанд өртсөн талбай		106438.2	+	-	-
үүнээс	Ажилчдын кемп	1280.6	+	-	-
	Олборлолтын талбай	17928.5	+	-	-
	Хөрсний овоолго	14465.7	+	-	-
	Ухсан нүх	45765.3	+	-	-
	Шороон зам	2621.1	+	-	-
	Нөхөн сэргээлт хийсэн талбай	24377.0	+	-	-
Б.Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа талбай		-	+	-	-
1.Үйл ажиллагаанд өртөөгүй талбай		-	+	-	-
үүнээс	Ашиглалт явагдаагүй газар	-	+	-	-
2.Үйл ажиллагаанд өртсөн талбай		-	+	-	-
үүнээс	Олборлолтын талбай	-	+	-	-
	Овоолсон шороо	-	+	-	-

13. Газрын гадарга, төлөв байдал:

Тус нэгж талбарын дунд хэсэгт олборлолтын талбай болон ухсан нүх , зүүн хэсэгт нөхөн сэргээлт хийсэн талбай болон нүүрсний овоолго, зүүн урд хэсэгт өнгөн хөрсний овоолго, урд хэсэгт ажилчдын кемп, шороон зам байна. Эзэмшил газрын баруун хэсгийн газар нь элэгдэл эвдрэлд бага өртсөн. Нийт эзэмшил газрын 2.5 хувь нь олборлолтын талбай, ажилчдын кемп, шороон зам нийлээд 0.5 хувь, хөрсний овоолго 2 хувь, ухсан нүх 6.25 хувь, нөхөн сэргээлт хийсэн талбай 3.3 хувь, 86 хувь нь ашиглалт явагдаагүй газар байна.

14. Хөрсний доройтол, бохирдолт, түүний төрөл, зэрэглэл:

Уулын хүрэн хөрстэй, газрын гадарга бага зэрэг налуу.

Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээжний дугаар	Дээж авсан гүн, см	Жижиг хэсгийн эзлэх хэмжээ мм, хувиар						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	0-20	10.4	59.0	22.3	4.8	8.3	16.2	29.2
	20-40	13.9	51.6	24.3	8.8	10.1	17.0	36.0
	40-60	8.1	57.3	21.9	9.2	12.6	17.2	39.0
2	0-20	23.2	48.6	19.6	6.7	8.6	13.3	28.6
3	0-20	8.6	52.4	26.1	9.4	13.0	16.3	38.6
4	0-15	18.6	60.3	14.9	4.8	6.3	12.9	23.9
	15-30	13.1	60.6	17.1	5.2	9.2	22.5	36.8
6	0-20	21.7	58.2	15.6	6.5	4.5	7.9	18.9

Энэ хөрс нь хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна.

Хөрсний агрохимийн шинж чанар

Дээжний дугаар	Дээж авсан гүн, см	pH	ЦДЧ, dsm	Давс, %	Ялзм аг, %	NO ₃ , мг/100г	Солилцох суурь, мг-экв/100гр			Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
							Ca+Mg	Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
1	0-20	6.41	0.080	0.027	2.97	0.15	20	12	8	1.4	15
	20-40	6.55	0.033	0.011	3.74	0.11	34	27	7	1.6	13
	40-60	8.11	0.083	0.028	2.46	0.22	27	18	9	1.3	15
2	0-20	8.70	0.078	0.026	1.47	0.08	17	9	8	2.2	13
3	0-20	7.77	0.419	0.140	2.82	0.31	28	19	9	1.6	11
4	0-15	7.43	0.087	0.029	2.21	0.23	12	5	7	1.9	21
	15-30	7.42	0.050	0.017	2.48	0.12	28	20	8	1.5	19
6	0-20	8.06	0.123	0.041	2.17	0.16	12	4	8	1.8	59

Хөрсний ялзмаг агууламж дунд, урвалын орчин шүлтлэг, 100 гр хөрсөнд агуулагдах хөдөлгөөнт фосфорын агууламж дунд, калийн хэмжээ дунд, шингээгдсэн сууриудын нийлбэрийн хангамж дунд зэрэг.

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж

Дээжний дугаар	Дээж авсан гүн, см	Хүнд металлын агууламж, мг/кг					
		Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Zn /Цайр/	Cr /Хром/	Cu /Зэс/
2	0-20	18.1	0.0	25.2	51.6	32.9	12.1
3	0-20	13.9	0.0	26.7	42.8	21.2	23.4
4	0-15	15.3	0.0	35.2	49.6	28.9	21.8
6	0-20	21.8	0.0	38.5	47.2	34.1	27.2
Хүлцэх агууламж /MNS 5850:2008/		100	2	70	150	100	80
Хортой агууламж /MNS 5850:2008/		1000	10	500	600	400	500
Аюултай агууламж /MNS 5850:2008/		1800	20	1200	1000	1500	1000

Хөрсний хүнд металлын агууламжийн хувьд кадми илрээгүй, бусад элементүүд "Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ".MNS 5850:2008 стандартад заасан хэмжээнээс бага байна.

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ, 1 гр хөрсөнд

Дээж авсан цэгийн дугаар	Шинжилгээний үзүүлэлт	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Бохирдолын үнэлгээ
5	Нянгийн тоо MNS6341:2012	1.0*10 ⁵	-	-
	Гэдэсний савханцарын тарьц (E.Coli) MNS ISO 5367:2004	1	1	Бага бохирдолтой
	Перфринген-сийн таньц MNS 6341:2012	0.1<	1	Бага бохирдолтой

Ажилчдын байрны орчмоос авсан хөрсний дээжинд гэдэсний савханцар болон перфрингенс, нянгийн бага зэргийн бохирдолтой гэсэн үнэлгээтэй байна

15. Ургамлын нөмрөгийн төрх байдал, доройтлын зэрэглэл:

Тус нэгж талбарт Үетэнгээс Гялгар Дэрс, Соргүй согоовор, Саман ерхөг, Нангиад цагаан суль, Хазаар өвс, улалжнаас Ширэг улалж, буурцагтанаас Бяцхан навчит харгана, Нумраа хунчир, Шар царгас, Эвлэг гиш, алаг өвснөөс Харлаг өмхий өвс, Дэрэвгэр хависгана, Шоргор лууль, Сортой лууль, Сибирь шорной, Өнхрүүш хамхуул, Саваан булган сүүл, хоёр наст согоот, Имт гичгэнэ, Агь, Жинхэнэ ерөмтүүл, Цагаан лууль, Үслиг манан хамхаг, Баг хуш хамхаг, Халбаган бираага, Толгодын бударгана, Зэрлэг олс, Дэгнүүлт шарилж, Цорол Халтаргана, Үслиг манан хамхаг гэх мэт зонхилно.

Ургамлан бүрхэвчийн төлөв байдал

Бэлчээрийн хэв шинж	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц, хувиар		Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Талхлагдлын заагуур	Халцгай газрын хэмжээ, %	Хад, чулууны хэмжээ, %	Ургац ц/га
	1м ² талбайд	10м ² талбайд	1м ² талбайд	10м ² талбайд				
Дэрс-улалжит								
1-р цэг	75.1	80	17	18	4	19.9	5	4
2-р цэг	70.5	80	18	18	3	26.5	3	2.8
3-р цэг	80.5	85	18	18	4	16.5	3	3.2

Тухайн талбар нь дунджаар зүйлийн бүрэлдэхүүн 14-16 ширхэг, тусгаг бүрхэц 75.3 хувь, ургац 3.3 ц/га, дундаж өндөр 12 см байгаагаас үзэхэд дунд сул доройтол орсон байна.

16. Газар ашиглалтын зөрчил, аюулгүй байдал:

Газар ашиглалтын аюулгүй байдал, техникийн нөхцөл зөрчигдөөгүй боловч ухсан нүхэнд хүн мал унах, ус дүүрэх, эрэг нурах зэрэг эрсдэл гарч болзошгүй тул урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заасан аюулгүй ажиллагааг хангаж ажиллах хэрэгтэй хэрэгтэй.

17. Газар ашиглалтын талаар цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:

Нэгж талбарын дунд хэсэг дэх газрыг олборлолтын талбай болгосон, мөн зүүн хэсэгт нөхөн сэргээлт хийсэн талбай болон нүүрсний овоолго, зүүн урд хэсэгт өнгөн хөрсний овоолго, урд хэсэгт ажилдын кэмп, шороон замтай, баруун хэсгийн газар нь элэгдэл эвдрэлд бага өртсөн, уулын хүрэн хөрстэй, ахуйн хог хаягдалгүй байна.

Олборлолт явуулж байгаа хэсэгт авто машин техникийн нөлөөгөөр хөрсний өнгөн хэсэг, ургамлан нөмрөг доройтсон байна.

Иймд газрыг нөхөн сэргээх, ургамалжуулах талаар төлөвлөгөө гаргаж ажиллах, хянан баталгааны ажлыг 5 жил тутам хийлгэж байх, хөрс, ургамлыг химийн болон бусад бохирдлоор бохирдохоос сэргийлэх, үржил шимт хөрсний овоолгыг тусад нь овоолох, ухалт хийсэн газрыг дүүргэх, нэгдсэн журмаар зорчиж байх цардаж сайжруулсан зам барьж байгуулах, уурхайн үйл ажиллагаанаас гарах хүнд техник хэрэгслээс ялгарах нефть, ахуйн болон үйлдвэрлэлийн хатуу хог хаягдлыг ангилан ялгаж тогтсон цэгт төвлөрүүлэн зориулалтын тагтай, салхи шуургатай үед хог хаягдал хийсч орчноо бохирдуулахгүй байх тал дээр анхаарч, байгаль орчинд нөлөөлөхгүй байдлаар устгах, булж тэгшлэх, аюулгүй болгох. "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө" -нд тусгасан Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч хэрэгжүүлж байх шаардлагатай

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
УЛСЫН ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ц.ГАНХҮҮ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН
ӨВӨРЧУЛУУТ ХЭМЭЭХ ГАЗАР БАЙРЛАХ
“БАЯЛАГ ОРД” ХХК-ИЙН MV-000222 ТООТ
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ
ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН
БАТАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

УЛААНБААТАР

2020



**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 18 өдөр

Дугаар 4/75

Улаанбаатар хот

Нөөцийг хүлээн авч, бүртгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн ХХ-06-06 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших MV-000222 тоот тусгай зөвшөөрөлтэй Өвөрчулуутын хүрэн нүүрсний ордод 2018 онд гүйцэтгэсэн тодотгол тооцооны ажлын үр дүнгийн тайлан дахь геологийн нөөцийг нийт баттай, бодитой болон боломжтой (A+B+C) зэрэглэлээр 2,874.67 мян.тн-оор хүлээн авсугай.

2. Хүлээн авсан геологийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэж, нөөцийн хөдөлгөөн хийхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв /Н.Мөнхбилэг/-д зөвшөөрсүгэй.

3. Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших MV-000222 тоот тусгай зөвшөөрөлтэй Өвөрчулуутын хүрэн нүүрсний ордод 2018 онд гүйцэтгэсэн тодотгол тооцооны ажлын үр дүнгийн тайланг бичвэр дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны дүгнэлт, түүний дагуу гаргасан АМГТГ-ын даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг "Баялаг орд" ХХК /Д.Чулуунбаатар/-д даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН

10 1190



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2019 оны 04 сарын 15 өдөр

Дугаар XX-06-06

Улаанбаатар хот

Баянхонгор аймгийн Галуут сумын нутаг дахь
Өвөрчулуутын хүрэн нүүрсний ордод 2018 онд
гүйцэтгэсэн тодотгол тооцооны ажлын үр
дүнгийн тайланг хэлэлцсэн тухай

Баянхонгор аймгийн Галуут сумын нутаг дахь Өвөрчулуутын хүрэн нүүрсний ордод 2018 онд гүйцэтгэсэн тодотгол тооцооны ажлын үр дүнгээр Монгол Улсын мэргэшсэн геологич Б.Энхтуяа, Ч.Энхжаргал, геологич С.Батжаргал нарын боловсруулсан тайлан, уг тайлан дахь нөөцийн тооцоонд Монгол Улсын зөвлөх геологич А.Чимэддорж, мэргэшсэн геологич Л.Алтан-Эрдэнэ нарын хийсэн шинжээчийн дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд дараах ДҮГНЭЛТ-ийг гаргав. Үүнд:

1. Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших Өвөрчулуут нэртэй ашигт малтмалын MV-000219 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМХЭГ-ын даргын 1996 оны 10 дугаар сарын 26-ны өдөр “Баялаг орд” ХХК-д анх олгожээ.

АМХЭГ-ын даргын 1997 оны 09 дүгээр сарын 19-ны өдөр дээрх ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаарыг MV-000222 гэж өөрчлөн 72 га талбайг “Баялаг орд” ХХК-ийн эзэмшилд шинэчлэн бүртгэжээ.

Өвөрчулуутын хүрэн нүүрсний орд нь Улаанбаатар хотоос 670 км, Баянхонгор аймгийн төвөөс 45 км, Галуут сумаас 40 км-г оршино.

2. “Баялаг орд” ХХК нь Өвөрчулуутын хүрэн нүүрсний ордод 2018 онд өөрийн хөрөнгөөр геологи, хайгуулын ажлыг гүйцэтгэж, ордын геологийн нөөцийг баттай, бодитой болон боломжтой (А+В+С) зэрэглэлээр тогтоож, хайгуулын ажилд 32 604 900 төгрөг зарцуулсан байна.

3. Тусгай зөвшөөрлийн талбай орших дүүргийн хэмжээнд шатах ашигт малтмалын хувьд 1971 онд Жаргалантын нурууны баруун өмнөд хэсэгт Баянхонгорын Геологийн Удирдах Газрын Хайгуулын 7-р анги, геологич Л.Мөнхтоогогийн удирдлагаар Өвөрчулуутын нүүрсний эрэл үнэлгээг урьдчилсан хайгуулын түвшинд хийж гүйцэтгэсэн байдаг.

Энэ ажлын үр дүнд 1977 онд Баянхонгор аймгийн төв, ойролцоох сумуудын түлшний хэрэгцээг хангах зорилгоор нүүрсний ордын ашиглалтын ажил эхэлсэн ба Өвөрчулуутын хүрэн нүүрсийг олборлохоор Баянтээгийн уурхайгаас хэсэг гарган 3-4 жил ажиллаад, нүүрсний чанарын шаардлага хангахгүй үндэслэлээр хаагдсан байдаг.

1980-1982 онуудад Өвөрчулуутын нүүрсний ордын нарийвчилсан хайгуулын ажлыг геологич А.Чимэддорж, Р.Эрдэнэчимэг нар гүйцэтгэж дэс дараалсан иж бүрэн судалгааны

үр дүнд дээд, доод 2 үеэс бүрдсэн 3500 ккал/кг дулаан ялгаруулах 3,8 сая тонны нөөц бүхий хүрэн нүүрсний орд болохыг тогтоожээ /БНМАУ-ын ГУУҮЯ-ны ШУТЗ-ийн 1981 оны №44 хуралдаан/.

4. Өвөрчулуутын хүрэн нүүрсний ордод 2018 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлаар ордын хэмжээнд нүүрсний өгөршил, исэлдлийн бүсээс 28 ширхэг нүүрсний дээж, 2 давхраасын гарш дагуу 2 суваг малтаж дээжилсэн байдаг.

Нүүрсний шинжилгээг Уул уурхайн хүрээлэнгийн Нүүрсний хяналтын шинжилгээний лаборатори, МАК-ын Технологи судалгааны төвийн лаборатори, нүүрсний цацраг идэвхит шинж чанрын шинжилгээг МХЕГ-ын ХАБҮндэсний лавалгаа, цацаргийн хяналтын итгэмжлэгдсэн лаборатори, 1:2000-ны масштабтай байр зүйн зураглалын ажил болон цооног, малталтуудын холболтын ажлыг “Тэнхлэг-Уул” ХХК тус тус гүйцэтгэжээ.

5. Өвөрчулуутын хүрэн нүүрсний орд нь доод цэрдийн Дөвөнт формацын нүүрс агуулагч тунамал хурдасанд байдаг. Уг орд нь нүүрсний 2 давхраасаас бүрдэнэ. Нүүрсний давхраасууд нь 5-8 хэмийн уналтай, жигүүр хэсэгтээ 1 м, төв хэсэгтээ 12-19 м, олборлолтын гүн 49,2 м байдаг.

Доод давхраас нь ордын талбайн хэмжээнд тогтмол зузаантай тархсан ба тархалтын талбайн хэмжээ 0.8х0.9км, давхаргын ашигтай зузаан 4.3-8.2 м, дунджаар 6.0-7.0 м, Нүүрсний давхраасын дунд 0.3-1.0 метрийн зузаантай 1-3 ширхэг чулуулгийн үенцэртэй байдаг.

Доод давхраасын нүүрсний чанарын үзүүлэлт нь 1980 онд авсан 305 ширхэг дээж, 2003-2017 онд ашиглалтын хайгуулын үед авсан 21 ширхэг дээжийн шинжилгээний үр дүнгээр нүүрсний дэгдэмхий бодисын гарц (V^{daf}) 41.0%, ажлын чийг (W^{ad}) 8.7%, аналитик чийг (W_a) 2.40-5.23%, дундажаар 4.40%, шатах хэсгийн илчлэг 6634 ккал/кг, нийт хүхрийн хэмжээ (S^i) 0.9%, үнслэг (A^d) 18.4% байжээ.

Дээд давхраас нь ордын хэмжээнд дээд давхарга нь харцангуй хязгаарлагдмал буюу 0,5х0,52км талбайд, бүтэц, зузааны хувьд хэлбэлзэл бага бөгөөд давхраасын ашигтай зузаан 4.5-9.4 м, дундаж зузаан 7.0 м, нүүрсний давхраасын дунд 0.1-0.8 метрийн 1-4 ширхэг чулуулгийн үенцэртэй байдаг.

Дээд давхраасын нүүрсний чанарын үзүүлэлт нь дэгдэмхий бодисын гарц дундажаар 46.30%, ажлын чийг (W^{ad}) дундажаар 9.4%, шатах хэсгийн илчлэг 6251 ккал/кг, нийт хүхрийн хэмжээ 0.79%, үнслэг (A^d) дундажаар 18.1% байжээ.

Монгол Улсын нүүрсний ангилалын MNS 6456:2014 стандартын дагуу Өвөрчулуутын хүрэн нүүрсний орд нь Х2-Х3, Оросын ангилалаар Б2-Б3 гэсэн ангилалд хамрагдсан байдаг. Ордыг I бүлгийн ордод хамааруулжээ.

6. Зохиогчид Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших Өвөрчулуутын хүрэн нүүрсний ордын геологийн нөөцийг баттай (А) зэрэглэлээр **710.49** мян.тн, бодитой (В) зэрэглэлээр **761.59** мян.тн, боломжтой (С) зэрэглэлээр **1402.53** мян.тн, баттай, бодитой болон боломжтой (А+В+С) зэрэглэлээр **2874.68** мян.тн гэж тооцоолжээ. Үүнээс А+В+С зэргээр **312.29** тн нүүрсийг складанд байгаа өгөршсөн нөөц гэсэн байна.

Шинжээчид дээрх нөөцийн тооцоог хянаж, дахин тооцоод ордын нөөцийг зохиогчийн хувилбараар хүлээн авахыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн гишүүдэд санал болгосон ба хуралдааны үед зөвлөлийн гишүүдийн олонхын саналыг үндэслэн ордын нөөцийг зохиогчийн хувилбараар хүлээн авч, ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг зүйтэй гэж үзэв.

7. Зохиогчид Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших Өвөрчулуутын хүрэн нүүрсний ордын нөөцийн тооцоонд дараах жишгийн үзүүлэлтүүдийг авч хэрэглэсэн байна. Үүнд:

- Нүүрсний давхраасын ашиглаж болох хамгийн бага зузаан - 1.00 м
- Нүүрстэй хамт ашиглах чулууны үеийн хамгийн их зузаан - 0.3 м
- Бохирдол тооцсон үнслэгийн хамгийн дээд хязгаар - 35%

8. Геологи, гидрогеологийн судалгаагаар доод Цэрдийн хурдас тархсан талбайн хэмжээгээр шахуу устай, ус нь элсэнцэр сайражин, хөрзөн чулуу, нүүрсний мэшил, үеүүдэд агуулагдах бөгөөд эдгээр үеүүд нь ус нэвчүүлэх шавар, зануужингийн салаавчлан тогтож нийлмэл, бага зэрэг түрэлтэт уст бүрдлийг үүсгэжээ.

Өвөрчулуутын хүрэн нүүрсний ордын хайгуулын үед өрөмдлөгийн ажлаар усны үе илрээгүй, олборлолтын үед карьераас ус шүүрэлт илрээгүй бөгөөд ундны болон ахуй хэрэглээний усаа Баянхонгор аймгийн төвөөс болон ойролцоох Дөвөнтийн алтны уурхайн гүний худагаас авч ашигладаг байна.

9. Техник эдийн засгийн урьдчилсан үнэлгээгээр ордыг 10 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн ба хөрөнгө оруулалт 614.88 сая төгрөг, татварын өмнөх ашиг жилд дунджаар 27 сая төгрөг, татвар төлсний дараа жилд 24.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар тооцжээ.

10. Цаашид техник-эдийн засгийн үнэлгээг боловсруулахдаа байгаль орчны үнэлгээнүүд, ТЭЗҮ-ийг эрх бүхий байгууллагаар үндэслэлтэй боловсруулах, ус ашиглах дүгнэлтийг холбогдох газраар гаргуулах, байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах ажлыг төлөвлөгөөний дагуу хийх, холбогдох хууль тогтоомж, ялангуяа Ашигт малтмалын тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан заавар, журмуудыг мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулахаар тогтов.

Нөөцийн тооцоонд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн УУХҮЯ, АМТТГ-ын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3, 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 45.3 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг АМТТГ-ын даргад уламжлахаар шийдвэрлэв. Үүнд:

Нэг. “Баянхонгор аймгийн Галуут сумын нутаг дахь Өвөрчулуутын хүрэн нүүрсний ордод 2018 онд гүйцэтгэсэн тодотгол тооцооны ажлын үр дүнгийн тайлан” дахь /Ордын нөөц 2018 оны 07 дугаар сарын 01-ний байдлаар/ геологийн нөөцийг баттай (А) зэрэглэлээр **710.49** мян.тн, бодитой (В) зэрэглэлээр **761.59** мян.тн, боломжтой (С) зэрэглэлээр **1402.60** мян.тн, баттай, бодитой болон боломжтой (А+В+С) зэрэглэлээр **2874.67** мян.тн-оор нүүрсний нөөцийг энэхүү дүгнэлтийн хавсралт №1-ийн дагуу хүлээн авах.

Хоёр. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан нүүрсний ордын геологийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв (Н.Мөнхбилэг)-д зөвшөөрөх.

Гурав. Дээрх нөөцийг хүлээн авсантай холбогдуулан ГУУҮЯ-ны Шинжлэх ухаан техникийн зөвлөлийн 1981 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн №44 тоот поротколоор бүртгэсэн Өвөрчулуутын хүрэн нүүрсний ордын нөөцөөс ашигт малтмалын MV-000222 тоот

тусгай зөвшөөрлийн талбайд оногдох (A+B+C) зэргийн 2948.16 мян.тн нүүрсийг хасч нөөцийн хөдөлгөөн хийхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв (Н.Мөнхбилэг)-д зөвшөөрөх.

Дөрөв. Энэхүү дүгнэлтийн 10-т заасан зүйлийг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг “Баялаг орд” ХХК (Д.Чулуунбаатар)-д анхааруулах.

Тав. Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, хээрийн судалгааны анхдагч баримт, тайлангийн бичвэрийн дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүний дагуу гаргасан АМГТГ-ын даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан, Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг “Баялаг орд” ХХК (Д.Чулуунбаатар)-д даалгах.

Зургаа. Баянхонгор аймгийн Галуут сумын нутаг дахь Өвөрчулуутын хүрэн нүүрсний ордод 2018 онд гүйцэтгэсэн тодотгол тооцооны ажлын үр дүнгийн тайлангийн боловсруулалт, түүний бүх төрлийн дээжлэлтийг Монгол Улсын мэргэшсэн геологич Б.Энхтуяа, Ч.Энхжаргал, геологич С.Батжаргал нар, өрөмдлөгийн ажлыг “GTS OD” ХХК, лабораторийн шинжилгээний үр дүнг МАК-ын Технологийн судалгааны төв, топо-геодезийн хэмжилтийн ажлыг "Тэнхлэг-Уул" ХХК тус тус хариуцах, тайлан, түүн дэх нөөцийн тооцоонд гаргасан шинжээчийн дүгнэлтийг Монгол Улсын зөвлөх геологич А.Чимэддорж, мэргэшсэн геологич Л.Алтан-Эрдэнэ хайгуулын ажлын үнэн бодит байдлыг “Баялаг орд” ХХК тус тус хариуцах.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ДАРГА:

Б.МӨНХТӨР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭБМЗ-ИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ
ДАРГА


А.ДЭЛГЭРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН

ЭБМЗ-ийн 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны
XX-06-06 дугаар дүгнэлтийн хавсралт



Өвөрчулуутын хүрэн нүүрсний ордын нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

/Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл MV-000222/
/Ордын нөөц 2018 оны 07 дугаар сарын 01-ний байдлаар/

Хүснэгт №1

Давхраас	Баттай (А)		Бодитой(В)		Боломжтой (С)		А+В+С		Өгөршсөн (С)		Нийт нөөц. мян/тн	
	цэвэр	бохир	цэвэр	бохир	цэвэр	бохир	цэвэр	бохир	цэвэр	бохир	цэвэр	бохир
Дээд			273.39	280.03	247.01	252.02	520.40	532.04	289.65	297.47	810.05	829.51
Доод	710.49	717.93	488.2	496.14	283.16	286.16	1481.84	1500.23	582.78	588.55	2064.62	2088.78
Дүн	710.49	717.93	761.59	776.17	530.17	538.18	2002.24	2032.27	872.43	886.02	2874.67	2918.29

НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮЛЭЭН
АВСАН ТУХАЙ АКТ

2024.11.12

№ 004

Номгон


Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 06 -ний өдрийн А/439 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны 01 сарын 20 – ний өдрийн А/22 дугаар захирамжаар томилогдсон тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дүгнэх, нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж авах комисс, Баянхонгор аймгийн Галуут сумын Сүмбэрийн 2 дугаар багийн нутаг дэвсгэрт “Өвөр чулуут” нэртэй газарт хүрэн нүүрсний олборлолтын чиглэлээр МУ – 000222 тусгай зөвшөөрөл бүхий “Баялаг орд” ХХК -ны 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон нөхөн сэргээлтийн байдалтай газар дээр нь танилцав. Тус компани нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийг 0 га, биологийн нөхөн сэргээлтийг 0.5 га, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд “Өвөр чулуут” нэртэй газарт 2 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийхээр төлөвлөсөн байна.

“Баялаг орд” ХХК нь аймгийн нөхөн сэргээлтийг хүлээж авах байнгын комисст төлөвлөгөөт техникийн нөхөн сэргээлтийг 0 га, биологийн нөхөн сэргээлтийг 0,5 га, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 3.5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг ажлыг хийж танилцуулав.

Комиссын шийдвэр:

“Баялаг орд” ХХК нь Галуут сумын Сүмбэрийн 2 дугаар багийн нутаг дэвсгэрт “Өвөр чулуут” чулуут нэртэй газар техникийн нөхөн сэргээлт хийсэн байдалтай ажлын хэсэг газар дээр нь үзэж танилцлаа. Тус компаний хийсэн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 3.57 га талбайд хийсэн техникийн нөхөн сэргээлт нь “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5917:2008 техникийн ерөнхий шаардлагыг хангаж байна гэж үзэв. Харин 0.5 га хийсэн биологийн нөхөн сэргээлтийг ургалт бүрэн гүйцэсний дараа буюу 2 жилийн дараа хүлээж авах боломжтой.

Хавсралтанд заагдсан солбицол бүхий 3.5 га техникийн нөхөн сэргээлт.

Ажлын хэсгийн ахлагч: Байгаль орчны газрын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч  Д.Содномсамдан



Нарийн бичгийн дарга: Байгаль орчны газрын Газар, газрын хэвлий, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний асуудал хариуцсан газрын ахлах мэргэжилтэн

Б.Наранбаатар

Гишүүд:

Байгаль орчны газрын байгаль орчны хяналтын Удсын байцаагч

Т.Мөнхжаргал

Байгаль орчны газрын усны асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Зүгдоржав

Галуут сумын байгаль хамгаалагч / БОХУБ/ С.Бадгаа

Галуут сумын Байгаль хамгаалагч

Д.Мөнхсайхан

Галуут сумын иргэний төлөөлөл

М. Баяртогтох

“Баялаг орд” ХХК – ны гүйцэтгэх захирал

Хүлээн зөвшөөрсөн:

Д.Ганбаатар



Баянхонгор аймгийн Галуут сум

0.57 га

id	grad	min	sec	grad	min	sec
1	46	22	8.55	100	7	40.43
2	46	22	7.87	100	7	40.51
3	46	22	7.05	100	7	38.01
4	46	22	7.31	100	7	37.5
5	46	22	11	100	7	37.06
6	46	22	9.98	100	7	39.57

Баянхонгор аймгийн Галуут сум



id	grad	min	sec	grad	min	sec
1	46	23	5.76	100	7	46.94
2	46	23	9.09	100	7	51.79
3	46	23	1.94	100	7	57.21
4	46	23	0.97	100	7	56.25

Баянхонгор аймгийн Галуут сум



id	grad	min	sec	grad	min	sec
1	46	22	53.99	100	7	45.25
2	46	22	57.77	100	7	48.93
3	46	22	56.74	100	7	52.33
4	46	22	51.47	100	7	47.96

Байгаль орчны газрын усны асуудал
хариуцсан мэргэжилтэн *Б. Зүндоржав*



Галуут сумын байгаль хамгаалагч /*Б. Зүндоржав*/ БОХУБ/ *С. Бадгаа* С. Бадгаа

Галуут сумын Байгаль хамгаалагч *Д. Мөнхсайхан* Д. Мөнхсайхан

Галуут сумын иргэний төлөөлөл *М. Баяртогтох* М. Баяртогтох



Хүлээн зөвшөөрсөн:
"Баялаг Орд" ХХК – ны гүйцэтгэх захирал

Д. Ганбаатар

Д. Ганбаатар